



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 5/64

Бор-Өндөр

Цагийн багшаар ажиллуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.5, 111 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мөнхтайваны Сүрэнхорлоо, Мягмарсүрэнгийн Нямжаргал нарыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2023-2024 оны хичээлийн жил дуустал хугацаанд англи хэлний хичээл заах цагийн багшаар тус тус ажиллуулсугай.

2. М.Сүрэнхорлоо, М.Нямжаргал нарын хичээл заасан нэг цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн заасан цагт ноогдуулан сар бүр бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Цагийн багш нарын ажлын байранд хяналт тавьж, ажилласан цагийн тооцоог үнэн зөв гаргахыг сургалтын менежер (М.Нармандах)-т, сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг англи хэлний багш (М.Сүрэнхорлоо), (М.Нямжаргал) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

